

**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03-р сарын 17-ны өдөр

№ ...03

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан
хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн 15 цагт **цахимаар** хуралдуулахаар товлосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
 - 2.3. Ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. Цахим хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2026 оны 4 сарын 10-ны өдрөөр** тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д хүргүүлэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2026 оны 03 дугаар сарын 24; 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2026 оны 03 дугаар сарын 19-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерын компанид хүргүүлэх, 2026 оны 03 дугаар сарын 24 болон 4 дүгээр сарын 08-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

7.2.Компанийн 2024\5 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд аудитын компаниас болон ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;

7.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

7.4. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга;

7.5. Хурлын зар.

8. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр, цахимаар санал хураах зөвлөмжийг Хавсралт 2-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар тус тус баталсугай.

9. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4 дүгээр 30-ны өдрийн 15 цагаар тогтоосугай.

10. Саналын хуудсыг хүлээн авах, тоолох тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: н. Д.Оюунчимэг

Гишүүд: Т.Удвал, Д.Оюунболор

11. Цахим хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Аюушийг томилсугай.

12. Цахимаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ажлыг энэхүү тогтоолын 2-р хавсралтаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс / Б.Аюуш /-д даалгасугай.

ДАРГА



Б.АЮУШ



“Баянгол зочид буудал” ХК-ийн ТУЗ-ийн
2026 оны 03 сарын 17-ны өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 01

**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргах шийдвэрийн талаар санал хураах ажиллагааг 2026 оны 4 сарын 10-ны өдрөөс 30-ны өдрийн 15 цагт хүртэл Улаанбаатар хот, СБД 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 5, Баянгол зочид буудал” ХК-ийн оффисын байранд биеэр ирж саналаа өгөх, эсвэл info@bayangolhotel.mn цахим хаягаар санал өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр:
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: Регистрийн дугаар:
Санал өгөх хувьцааны тоо:
Бүртгэсэн:
/Үнэт цаасны компанийн нэр/
Брокерийн овог: нэр:

Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан
1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;		
2. Компанийн ТУЗ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;		

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/
Тооллогын комиссын дарга...../гарын үсэг/
Гишүүд...../гарын үсэг/.....

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр компани дээр ирж хурлын материалтай танилцах юмуу info@bayangolhotel.mn цахим хаягаар санал авах хуудсаар саналаа өгнө. Биеэр ирж санал өгсөн тохиолдолд саналын хуудсыг хүлээн авсан этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.
3. Цахимаар саналаа өгөх бол зард заасан цахим хаягараа саналын хуудас бөглөж ирүүлэх бөгөөд цахим шууданд өөрийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргасан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 312255 утсаар лавлаж болно.

Саналын	хуудсыг	хүчингүйд	тооцсон	бол	шалтгаан:
---------	---------	-----------	---------	-----	-----------

.....



“Баянгол зочид буудал” ХК-ийн ТУЗ-ийн
2026 оны 03 сарын 17-ны өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 02

**Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн танилцах
бичиг баримтын жагсаалт, бэлэн болох хугацаа**

1. Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр 2026.03.17
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт 2026.03.27
3. ТУЗ-ийн төсөв 2026.03.27

Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл зэрэг нь 2026 оны 3-р сарын 27-ны өдөр гэхэд бэлэн болох ба Улаанбаатар хот, СБД, 1.-р хороо, Баянгол зочид буудал” ХК-ийн өөрийн байранд, компанийн цахим хуудсанд болон өөрт үйлчилдэг брокерын компани дээр очиж танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комисс

Зарын загвар



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хуралдуулах ажиллагааг 2026 оны 4 сарын 30-ны өдрийн 15 цагт зохион байгуулах болсныг мэдэгдэж байна. Та бүхэн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 5, “Баянгол зочид буудал” ХК-ийн оффисын байранд 2026 оны 4 дүгээр сарын 10-наас 2026 оны 4 дүгээр сарын 30 хүртэл хугацаанд ажлын өдрүүдэд ажлын цагаар ирж, шийдвэр гаргахтай холбогдох материалтай танилцаж саналын хуудсаа бөглөх, эсвэл компанийн info@bayangolhotel.mn цахим хаягаар материалтай танилцаж, уг цахим хаягаар саналын хуудсаа ирүүлэх замаар саналаа өгөх боломжтой.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 4 сарын сарын 10-ны өдөр.

Хурлаар хэлэлцэх болон танилцуулах асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
3. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.

Гарах шийдвэрийн төсөл болон холбогдох бичиг баримттай 2026 оны 3 сарын 27-ноос хойш ажлын өдрүүдэд 10-17 цагийн хооронд компани дээр ирж танилцах, өөрийн үйлчилдэг брокерын /үнэт цаасны/ компани дээр очиж танилцах, компанийн info@bayangolhotel.mn цахим хаягаар хурлын материалтай танилцах боломжтой.

“Баянгол зочид буудал” ХР-ийн ТУЗ-ийн
2026 оны 03 сарын 17 өдрийн 1 тоот тогтоолын Хавсралт 3



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС ЦАХИМААР САНАЛ ХУРААХ, ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Цахимаар санал хураах ажиллагааг дараах дэс дарааллаар зохион байгуулна. Үүнд:

1. Цахимаар санал хураах тухай ТУЗ-ийн шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлсний дараа буюу 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерын компанид хүргүүлэх, 2026 оны 03 дугаар сарын 24 болон 4 дүгээр сарын 08-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр болон олон нийтийн сүлжээгээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх ажлыг хурал зохион байгуулах комисст хариуцан хэрэгжүүлэх.
2. Шийдвэр гаргахад оролцож санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгон гаргасан нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс хүлээн авсны дараагийн өдрөөс буюу 2026 оны 4 дүгээр сарын 11-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15 цаг хүртэлх хугацаанд компанийн оффист хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн биеийн байцаалтыг санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган шалгаж, хувьцаа эзэмшигч мөн болохыг баталгаажуулсны дараа нэрийг нь бүртгэлийн жагсаалтад бүртгэж, шийдвэр гаргахтай холбоотой бүх асуудлыг танилцуулах, санал авах хуудсыг бөглүүлэн авч, битүүмжилсэн хайрцагт хийнэ.
3. Компанийн цахим хаягаар ирсэн саналын хуудсыг Шийдвэр гаргахад оролцож санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тасалбар болгон гаргасан нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс хүлээн авсны дараагийн өдрөөс буюу 2026 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш өдөр бүр бүртгэн авч, жагсаалттай тулган шалгаж санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал мөн бол жагсаалтад бүртгэж, саналын хуудсыг хэвлэн битүүмжилсэн хайрцагт хийж хадгална.
4. Цахим санал хураалтаар шийдвэр гаргахаар тогтоосон өдөр буюу 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15 цагт Хурал зохион байгуулах комисс, Тооллогын комиссын гишүүд Баянгол рестораны зааланд битүүмжилсэн хайрцгийг нээх, санал тоолох, тооллогын дүнг гаргах, Тооллогын комиссын тогтоолыг болон хувьцаа эзэмшигчдээс цахимаар санал хураасан дүнгээр тогтоол албажуулан гаргах ажиллагааг ТУЗ-ийн дарга болон гишүүдийн хяналтын дор хэрэгжүүлнэ.
5. Энэхүү ажиллагаанд хяналт тавих хүсэлтэй хувьцаа эзэмшигч оролцох эрхтэй.

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Баянгол зочид буудал” ХК
Хаяг, утас:	Монгол Улс, Улаанбаатар хот, СБД 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал. Утас: (+976)-11-312255
Хурал хуралдах өдөр, цаг: Тайлбар:	2026 оны 4-р сарын 30-ны өдөр 15.00 цаг хүртэл “Саналын хуудас”-аар санал авах бөгөөд энэ өдөр энэ цагт цахимаар хуралдана.
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Саналыг компанийн төв оффист болон компанийн info@bayangolhotel.mn цахим хаягаар хүлээн авах бөгөөд 2026 оны 4-р сарын 30-ны өдөр 15.00 цагт цахимаар хуралдаж, хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комисс компанийн төв байранд ТУЗ-ийн хяналтын дор саналын хуудсыг тоолж, шийдвэрийг албажуулна.
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 03-р сарын 17-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 03-р сарын 24 болон 4-р сарын 08-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2026 оны 4-р сарын 10-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2026 оны 03-р сарын 27-ны дотор
Хүргүүлсэн огноо:	2026 оны 03-р сарын 19-ны өдөр
Хурлын даргын нэр:	Б.Аюуш
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Д. Оюунчимэг, Т.Удвал, Д.Оюунболор
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Албан бичиг, Хурал хуралдуулах тухай шийдвэр, Зарын загвар, Саналын хуудасны загвар, Хурлаар танилцах бичиг баримтын жагсаалт, Хурлын дэг, ТУЗ-ийн хурлын тэмдэглэл
Баримт, бичгийн хуудасны тоо:	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА



[Signature]

/Б.Аюуш /

2026 оны 03-р сарын 19 өдөр